



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын  
үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг шинэчлэн бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15, Хорооны 2013 оны 452 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг бүртгэх тухай журам”-ын дагуу үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудитын компаниар бүртгэгдсэн дараах нэр бүхий компаниудыг үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр шинэчлэн бүртгэсүгэй.

1. “Конфиденсе-Аудит” ХХК;
2. “Далайван-Аудит” ХХК;
3. “БДО аудит” ХХК;
4. “Прайсуотерхаускуперс-Аудит” ХХК;
5. “Сүлд-Аудит” ХХК;
6. “Тэд-Аудит” ХХК;
7. “Эс-Эм-Аудит” ХХК;
8. “Ситико-Аудит” ХХК;
9. “Кэй Пи Эм Жи аудит” ХХК;
10. “Делоитт онч Аудит” ХХК;
11. “Улаанбаатар-Аудит корпораци” ХХК;
12. “Эрнст энд Янг монголия аудит” ХХК;

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг дээрх нэр бүхий компаниудын захирлуудад үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000009